

ГАЗРЫН ХЭМЖЭЭ ЗААСАН ХОЛБОО ҮГС

Г.Оюунчимэг*

Монголчуудын аж төрөх ёсны уламжлалын нэг нь газрыг хэмжиж тооцож ирсэн өнө эртний уламжлалтай бөгөөд тогтсон хэм хэмжээ нь харьцангуй бөгөөд хэдэн мянган жилийн турш өдөр тутмын амьдралд хэрэглэгдсээр ирсэн байна. Асар удам газар нутагтай, бэлчээр нүүдлийн аж төрөлтэй монголчуудын газрын хэмжээ заасан холбоо үгс баялаг бөгөөд өвөрмөц нийлцтэй сонин сэтгэлгээний онцлогтой байдгийг эрдэмтэд судалж, толь бичиг зэрэгт тэмдэглэсэн байх ба монгол ардын аман зохиол, аман хэллэг, аман ярианд өргөн хэрэглэгдсээр байгаа юм.

Газрыг хэмжиж ирсэн хэмжүүрийн зүйл олон төрөл бөгөөд гараар хэмждэг хэмжээс, хөлөөр хэмждэг хэмжээс, эдлэл юмсаар хэмжих хэмжээс, малын явдлаар хэмждэг хэмжээс, газрын хэмжүүрээр хэмжих хэмжээс, нүүдэл суудлаар хэмжих хэмжээс, байгалийн тогтцоор хэмжих хэмжээс, бэлчээрээр хэмжих хэмжээс, тусгалаар хэмжих хэмжээс гэх зэрэг олон янз бий.

1. Гараар хэмждэг хэмжээст газар:

Газарт ногоо цэцгийн үр суулгах үесэд хуруу гараар хэмжиж суулгадаг.

Хуруу газар-нэг хурууны өргөнөөр хэмнэсэн хэмийг нэг хуруу (Шагж.404.) **хуругун**-мера длины: полдюйма К.Ф.Голстунский М-р сл. 1938. т-2 стр.188. Нэг хурууны хэмийг нэг хуруу хэмээмүй. Таван пун. (Хорин нэгт тайлбар толь. 410)

Гуриу газар-гурван хурууны хэм. **Гуриу**-мера в три пальца А.Позднеев К-Р сл. С-П. 1911 стр.113.

Дөриү газар-дөрвөн хурууны хэм. **Дөриү**-мера в четыре пальца: К.М.Черемисов Б-М-Р сл.1951. стр.226.

Алга дарам газар-гарын алганы хиртэй талбайн хэмжээ. **Алга дарам газар** (Монгол хэлний толь. 69.) **Алга дарум-а** – А ширина руки; короткая пядень. (О.Ковалевский М-Р-Ф сл. том-3. стр 1674). К.Ф.Голстунскийн тодорхойлолтыг метрийн хэмжүүрт оруулбал нэг хуруу нь 1,25 см өргөн болно. Хүний бие эрхтний хэсгээр хэмжээлэх монгол ардын уртын хэмжүүрийн хоорондын харьцааг харгалзан үзвэл хурууны дундаж хэмжээг 2 см хэмээн үзэж болмоор аж. Тэгвэл хоёр хуруу нь 4 см, гуриу нь 6 см, дөриү нь 8 см, алга дарам нь 10 см-ийн дундаж хэмжээ болох юм. (Ч.Содном 17).

* МУИС-ийн МХСС-ийн докторант

Ямх газар-хоёр хурууг нэг ямх хэмээмүй. (Хорин нэгт тайлбар толь. 83) **ИМАQU**-эрхий хурууны дээр үеийн хэмжээс буюу. Бас нэгэн тохойн арван хувийн нэгж хувийг буюу. (Хорин наймтын толь 281). **ИМАХУ**-Два пальца (сложенные вместе), мера длины: Дюйм. (К.Ф.Голстунский М-р сл. СП.1895. т-1. стр.136). **Ямх**=10 пун (Шинэ толь. Уб.,1936.-3-4.346). **Ямх**-Хоёр хуруугаар хэмнэсэн хэмийг. Эдүгээ цун хэмээс нь хятад үг. (Шагж 96) Ямхын тухай тодорхойлолтоос үзэхэд ямхыг заримд нь нэг хуруу нөгөө заримд нь хоёр хуруу гэсэн үндсэн зөрөө гарч байна. Уул нь ямх бол эрхий хурууны үзүүрээс нэгдүгээр үе хүртэлх хэмжээ буюу нийлсэн хоёр хурууны өргөнтэй дүйх хэмжүүр аж. (Ч.Содном 18).

Сөөм газар- эрхий хуруу, хомхой хуруу сунгаж хэмнэсэн хэмийг сөөм хэмээмүй. (Хорин нэгт тайлбар толь 591), (Шагж 884).

Сөөм-короткая пядь (пространство между большим и указательным пальцами) (Я.Шмидт М-Н-Р сл. 1835. стр.373). **Мухар сөөм**- короткая, малая пядь (расстояние между раздвинутыми большим и указательным пальцами с подогнутыми двумя суставами). (А.Лувсандэндэв. Монгол-Орос толь 1957. М.,360-р тал).

Мухар сөөм нь 15 см, үзүүр сөөм нь 19 см хэмээн үзэж болно. (Ч.Содном 19).

Төө газар-эрхий хуруу, дундад хуруу сунгаж хэмнэсэн хэмийг төө хэмээмүй. (Хорин нэгт тайлбар толь. 672). **ТӨӨ**- пядень, расстояние между растянутыми большими и средними пальцами. Четверть (К.Ф.Голстунский М-р сл. 1938. т-3. стр.250)

Мухар төө-кучая пядь (расстояние между большим и средним пальцам с подогнутыми двумя суставами последнего. А.Лувсандэндэв 418).

Хүний дундаж өндрийг 165-170 см гэж санавал мухар төө нь 18 см, үзүүр төө нь 22 см хэмжээ аж. (Ч.Содном 19).

Тохой газар-Арван ямхыг нэг тохой хэмээмүй (Хорин нэгт толь 653), (Шагж 623),

Тохой - Локоть (мера, 10 вершков) О.Ковалевский М-Р-Ф сл. 1844. т.3. стр. 1797).

Нэг ямх нь хоёр хуруу, нэг хуруу нь 2 см гэж тоймловол нэг мухар тохой нь 16 хуруу буюу 32 см, нэг үзүүр тохой нь хорин хуруу буюу 40 см болохнээ. (Ч.Содном 20).

Дэлэм газар-Хагас алдыг дэлэм хэмээмүй (Хорин нэгт толь. 717), (Шагж 681),

Дэлэм-На сколько можно натянуть лук; полсажени. (Я.Шмидт М-Н-Р сл. 1835. стр.277).

Дэлэм-нэг алдын хагас. Тухайлбал нумыг дүүрэн дэлэхэд нум барьсан, хөвч татсан хоёр гарын хооронд үүсэх уртын хэмжээ. (Монгол хэлний толь 2575).

Алд газар-хоёр гарыг сунгаж нэгэнт хэмнэсэн хэм. (Шагж 43.) **Алд**-сажень (ручная в 2,5 аршина) (О.Ковалевский М-Р-Ф сл.1844. т-1. стр.86). **Алд**-Маховая сажень в пять футов. (К.Ф.Голстунский М-Р сл.1938. т-1. стр.46). Нэг алд таван тохой (Шинэ толь. Уб.,1936.346.)

Мухар тохойг 32 см урт, үзүүр тохойг 40 см урт буюу нэг мухар алдыг таван мухар тохойтой, нэг үзүүр алдыг 4,4 үзүүр тохойтой дүйнэ гэж үзвэл мухар алд нь 160 см, үзүүр алд нь 176 см болох юм. (Ч.Содном 21).

2. Хөлөөр хэмжих газрын хэмжээс:

Хагас алхам буюу өрөөсөн хөлийн алхам, **бүтэн алхам** буюу хоёр хөлийн алхам өрөөсөн хөл урагш нэгэнт дэвшүүлсэн хэмийг алхам гэнэ. (Шагж 39) **Алхам-шаг** (большой), мера в 5 футов. (К.Ф.Голстунский М-Р. Сл.1895. т.1. стр.132). Энд бүтэн алхамын тухай К.Ф.Голстунскийн тодорхойлолтыг метрийн хэмжүүрт оруулбал 150,5 см болж байна. Хүний алд, бүтэн алхам хоёр барагцаалбал 160-176 см. Тэгвэл хагас алхамын хэмжүүр нь 80-88 см байх нь (Ч.Содном 22)

Алцам газар-бүтэн алхамын хэмжээтэй бөгөөд гагцхүү хөл хажуу тийш алцайж хэмжих байдлаар алхмаас ялгарна.

Гишгэм газар-Баруун монголчууд тухайлбал торгууд нар гурван цуваа гишгэм нэг дэлэмтэй, зургаан цуваа гишгэм нэг алдтай дүйнэ гэж үздэг аж. (Ч.Содном 22).

3. Эдлэл юмсаар хэмжих хэмжээст газар:

Аргамжааны газар- Морь аргамжих сурын урт хирийн буюу 4-6 м урт эргэн тойрон газар. Тойрог газрын хэмжээс.

Таталгын газар-Ачаа татлага татдаг баглаа, хүлээ, татлагын сурын уртаар хэмжсэн 3-4 м хирийн газар.

Нумын газар-Нэг алхам газрыг нэг нумын газар гэнэ. (Шагж 209).

Нэг нум газар нь хоёр алхамтай тэнцдэг гэж ярилцдаг газар бас бий. (Ч.Содном 26)

Дэлгэрийн чинээ газар-Тохмын доор зөөлөн тохдог хөлсөвч тохмын төдий хэмжээний газар.

Тохмын чинээ газар-Эмээлийн тохмын хэмжээний газар.

Гэрийн чинээ газар-Монгол эсгий гэрийн буурийн чинээ газар.

Баян айлын хотон чинээ газар-Баян айлын хороо хотын чинээ өргөн дэлгэр газар.

Хормойн чинээ газар-Дөрвөн байр буюу эн бөсөөр нийлүүлж эхнэр хүний дээлийн хормой залгадаг. Тийм хэмжээний газар.

Малгайн чинээ газар-Монгол хүн малгайгаа толгой дээрээ тавьдаг учраас малгай нь толгойноосоо бага байдаг тул бага хэмжээний газрыг малгайн чинээн газар гэдэг.

4. Хүн малын явдлаар хэмждэг хэмжээст газар:

Өдөрчийн газар-Морь тэмээгээр өдөржин явж хүрэх газар.

Хоногийн газар-Морь, тэмээ, үхэр тэргээр хонон өнжин явж хүрэх газар.

Үдийн газар-Морь тэмээгээр үд хүртэл яваад хүрэх газар.

Сарын газар-Сар явж хүрэх газар.

Жилийн газар-Бүтэн жил буюу гурван зуун жаран таван хоног явж хүрэх газар.

Явганы газар-Явган яваад хүрэх ойрхон газар. Монгол хүн явганы газар гэж ярилцдаг боловч заншлаараа бол хэдий ойрхон явганы газар боловч явган явж айлд хүрдэггүй. Эрхбиш унаа хөлөглөж хүрдэг заншилтай. Бадарчин хүн бол хэдий ч явганы газар явдаг.

Жирэмсэн эмийн шээх газар -Тулгар биетэй жирэмсэн эмэгтэйн шээх газар гэрээс ойрхон тул ойр газрыг ийнхүү жишиж хэлдэг.

Хагас өдрийн газар-Унаа хөлөглөөд хагас өдөрт хүрэх газар.

Хугас үдийн газар-Унаагаар жин үд хүргэлгүй хүрэх ойрхон газар.

Бага үдийн газар-Нар мандаж байхад мордоод, нар хөөрч байхад хүрэх газар.

Жин үдийн газар-Нар мандаж байхад мордоод, жин үдэд хүрэх газар.

5. Газрын хэмжүүрээр хэмжих хэмжээст газар:

Газар-180 хос алдыг нэг газар гэнэ. (Шагж 409). Газрын хол ойрыг хэмжихэд 36 алдыг 1 хувь, арван хувийг нэг газар гэнэ. (Шинэ толь. 1936. № 3-4, 346).

Нэг газар нь зуун тавин хос алд (15 ен) буюу хагас километртэй тэнцэнэ. (Монгол хэлний толь. 1637). **ГАЗАР**-мера протяжения в 180 больших сажен (К.Ф.Голстунский М-Р сл. 1938. т.2. стр 209)

Мод газар-1,06 км-тэй тэнцэнэ. (Монгол хэлний толь.1862)

Бээр газар- О.Ковалевский, А.Лувсандэндэв нар бээрийг миль буюу 2 км орчим газар гэсэн нь харилцан дүйж байгаа бол Шагж гуай 8 хөрс газрыг нэгэн бээр газар гэжээ. Гэтэл Н.Сумадираднаа, О.Ковалевский, К.Ф.Голстунский нар хөрс газрыг 500 алд гэж тодорхойлсныг баримталбал 4000 алд буюу найман хөрстэй тэнцэнэ. (Монгол хэлний толь. 959).

Хөрс газар-Наймны нэг бээр буюу хоёр зуун тавин метртэй тэнцэхүйц уртын хэмжээ (Монгол хэлний толь. 1559).

Аршим газар-0,71 метр газрын уртын хэмжээс.

Эрвэй газар-Долоо найман тохой урт буюу насанд хүрсэн хүний хөлийн улаас өргөсөн гарын хурууны үзүүр хүртэлх зайн хэмжээс.

Хорилд газар-30,9 метртэй тэнцэнэ.

Хувь газар-36 алдыг нэг хувь.

Өртөө газар-30 км зайтай газар.

6. Нүүдэл суудлаар хэмжих хэмжээст газар:

Саахалтын газар-Айл буюу ойр саахалтын газар нь 1-2 км орчим, хошоо буюу хол саахалтын газар нь 3-5 км орчим газрыг хэлдэг байна.

Нүүдлийн газар-Хагас өдрийн газар 40-50 км, бүтэн өдрийн газар 90 км. Хоногийн газар 120-150 км, зуур хоногийн газар 210-220 км гэх мэт тоймлож болно.

Хотны газар-Айлын гэрээс хот хороо хүртэлх ойр зайн газар.

Ааль газар-Суудаг гэр, шүтээний гэр, хатдын гэр, зочны гэр тэргүүтнийг багтаасан газрын талбайн харьцангуй хэмжээст газар.

Хүрээ газар-Ноёны ааль хүрээ хамжлага нарын хүрээ сууц, шүтээн сүм, дуган гэхчилэн суурин газрын талбайн хэмжээ.

Гацаа газар-Айл аймгаар суурьшсан газрын талбайн хүрээ.

Тосгон газар-Айл, аймаг, хүрээ, эдлэл газар, байшин барилга хосолсон суурьшмал газрын талбайн хэмжээс.

Суман газар- Засаг захиргааны нэгж газрын хэмжээс.

Суурин газар- Бөөнөөр суурьшсан газрын талбайн хэмжээс.

Хот газар-Үйлдвэрлэл эрхэлж, соёл иргэншил дэлгэрсэн суурьшмал газрын ерөнхий талбайн хэмжээс.

7. Байгалийн тогтцоор хэмжигдэх газар:

Уул уулаар хэмжим газар, нуураар хэмжим газар, тал газар, нүд алдам тал газар, хотгор газар, хонхор газар, хөндий газар, хоолой газар, ам газар, дов газар, хонхцог газар, толгой газар, нахис газар, хотос газар, энгэр газар, ар газар, хаялга газар, хошуу газар, майл газар, цоорхой газар, хавцал газар, хангай газар, ханхай газар, суга газар, судаг газар, цээл газар, эрэг газар, ирмэг газар, бэл газар, бэлчир газар, уудам газар, уужим газар, тавиу газар, цухал газар, хавчиг газар, гэх мэт.

8. Бэлчээрээр хэмжих хэмжээст газар:

Морины аргамжааны газар -25-50 м.

Хонины бэлчээрийн газар – 1-2 км.

Үхрийн бэлчээрийн газар – 2-2,5 км.

Тугалын бэлчээрийн газар -1 км.

Хурганы бэлчээрийн газар-500 м-1 км.

Адууны бэлчээрийн газар- 4 км орчим.

Бярууны бэлчээрийн газар 1,5-2 км.

Бэлчээрээр хэмжих хэмжээст газрын зайн үг хэллэг *Бярууны бэлчээрээс хол газар яваагүй босгоноос өндөр даваа даваагүй* гэх зэрэг зүйр цэцэн үг маш элбэг байдаг нь эрхлэх аж ахуй, хэвшил дадалтайгаа нягт холбоотой байна. Бэлчээрийн газрын зайн хэмжигдэхүүн нь газар газарт тогтсон ахуйн хэвшилтэй шууд холбоотой тогтсон зайн хэмжигдэхүүн дадал заншил юм.

9. Тусгалаар хэмжигдэх хэмжээтэй газар:

Хүүшлэн газар-Уулын сүүдэр тусах газрын хэмжээс.

Сум тусах газар-Нум сумны тусгал газрын хэмжээс.

Зэв тусах газар-Байлдааны нумаар харваж зэв тусах газрын хэмжээс.

Summary

Any kind of attributes can be measured including physical quantities such as distance, land etc. Mongolians had many ways to measure the land including measure by hand, things, comparison with formation of nature, pasture etc. Compound words that indicate the measurement is nomenclature compound words. Mongolians have been using these compound words steadily in their daily lives for ages.

Ном зүй

1. Я.Шмидт. (1835) Монгольско-Немецко-русский словарь. СПб.
2. О.Ковалевский. (1844) Монгольско-Русский словарь. С-П. т.1.2.3.
3. К.Ф.Голстунский. (1938) Монгольско-Русский словарь. С-П.1893-95. т.1.2.3; Л., т.1.2.

4. А.Позднеев. (1911) Калмыцко-Русский словарь. С-П.
5. К.М.Черемисов. (1973) Бурят-Монгольско-Русский словарь. М.
6. Шагж. (1994) Монгол үгний тайлбар толь. Бээжин.
7. Ч.Содном. (1968) Монгол ардын уртын хэмжүүр // *Studia museologica* т.1, F3. Уб., 13-35.
8. Норжин. (1999) Манмөрөн. Монгол хэлний толь. Хөх хот.
9. Хорин нэгт тайлбар толь. (1979) Хөх хот.
10. Хорин наймт тайлбар толь. (1994) Хөх хот.
11. А.Лувсандэндэв. (1957) Монгол-Орос толь. Уб.,
12. Монгол орос дэлгэрэнгүй их толь. (2001) Москва.
13. А.Пүрэвжанцан. (1999) Монголчуудын хэмжээ илэрхийлэлийн товч тайлбар толь. Уб.,